

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**“АТҮТ” ТӨҮГ-ын Булган аймаг дахь Авто тээврийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**Аудитын код: БУА-2022/4/НА-СТА-ТБОӨААН**

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Булган аймаг

2022 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр

Утас: 70342580 Цахим хаяг: ankhbayard@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716 Цахим хаяг: enhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: Б.Пүрэвсүрэн

Утас: 70353717 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан .....	4
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	5
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	6
3. Санхүүгийн тайлангийн тодруулга .....	8
3.1 Байгууллагын үйл ажиллагаа .....	8
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин .....	8
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого .....	9
4. Аудитын тайлан .....	12
4.1 Ерөнхий зүйл .....	12
4.2 Дотоод хяналт .....	12
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
4.4 Материаллаг байдал .....	13
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
5.1 Шилэн дансны мэдээлэл .....	13
6. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	14
8. Аудитын илрүүлэлт .....	14
8.1 Залруулсан алдаа .....	14
8.2 Төлбөрийн акт .....	<b>Error! Bookmark not defined.</b>
8.3 Албан шаардлага .....	<b>Error! Bookmark not defined.</b>
8.4 Зөвлөмж .....	14
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	16

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББ	Нягтлан бодох бүртгэл
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТУЗ	Төлөөлөн Удирдах Зөвлөл

## 1.Аудитын санал дүгнэлт



### БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс:7034-3259  
E-mail:bulgan@audit.gov.mn

2022.03.15 № 268  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

АВТО ТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ  
ТӨВИЙН БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
САЛБАРЫН ДАРГА Ж.БАТЗОРИГ  
ТАНАА

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Авто тээврийн үндэсний төвийн Булган аймаг дахь салбарын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Авто тээврийн үндэсний төвийн Булган аймаг дахь салбарын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


D:/bichighereg/2022A4toot

006020345

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБӨУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

D:/bichighereg/2022A4toot

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,733,089.08	48,000.00
1.1.06	Бараа материал	11,208,462.41	9,993,965.63
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	12,941,551.49	10,041,965.63
1.2.01	Үндсэн хөрөнгө	585,317,029.26	570,376,587.89
1.2.02	Биет бус хөрөнгө	28,090,000.00	28,090,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	613,407,029.26	598,466,587.89
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>626,348,580.75</b>	<b>608,508,553.52</b>
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	2,462,076.00	6,597,816.01
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,462,076.00	6,597,816.01
2.2	Өр төлбөрийн нийт дүн	2,462,076.00	6,597,816.01
2.3.04	Төв компанийн тооцоо	923,193,421.62	881,342,488.59
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	17,824,462.50
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	9,000,000.00	9,000,000.00
2.3.09	Хуримтлагдсан ашиг	308,306,916.87	306,256,213.58
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	2,050,703.29
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	308,306,916.87	308,306,916.87
2.3.11	Эздийн өмчийн дүн	623,886,504.75	601,910,737.51
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>626,348,580.75</b>	<b>608,508,553.52</b>

### 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	254,896,403.63	298,264,240.90
02	Борлуулалтын өртөг	264,334,081.85	280,937,336.44
03	Нийт ашиг( алдагдал)	-9,437,678.22	17,326,904.46
04	Түрээсийн орлого	0.00	0.00
05	Хүүгийн орлого	69,318.57	0.00
06	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
07	Зорчигч тээврийн орлого	17,177,032.02	7,926,160.00
08	Бусад орлого	0.00	0.00
08.1	Орлогын дүн	17,246,350.59	7,926,160.00
09	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	21,646,760.43	22,082,761.15
11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Бусад зардал	174,379.00	119,600.02
12.1	Зардлын дүн	21,821,139.43	22,202,361.17
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00

**“АТҮТ” ТӨҮГ-ын Булган аймаг дахь Авто тээврийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг ( алдагдал)	-320,000.00	-1,000,000.00
17.1	Олз, гарзын дүн	-320,000.00	-1,000,000.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)	-14,332,467.06	2,050,703.29
19	Орлогын татварын зардал	0.00	0.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-14,332,467.06	2,050,703.29
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)	-14,332,467.06	2,050,703.29
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
23.3	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	0.00	0.00
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

**2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
09	2020 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	0.00	932,193,421.62	-308,306,916.87	623,886,504.75
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө,алдааны залруулга	0.00	-41,850,933.03	0.00	-41,850,933.03
11	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	2,050,703.29	2,050,703.29
13	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00
14	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
15	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	17,824,462.50	0.00	0.00	17,824,462.50
17	2021 оны 12 сарын 31-р үлдэгдэл	17,824,462.50	890,342,488.59	-306,256,213.58	601,910,737.51

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
0	Мөнгөн хөрөнгөөс мөнгөн хөрөнгө рүү бичсэн гүйлгээ	0.00	0.00
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	679,199,526.90	563,126,295.18
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	297,036,262.00	236,507,991.01
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	0.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.00	0.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	0.00	0.00

**“АТҮТ” ТӨҮГ-ын Булган аймаг дахь Авто тээврийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	251,360,734.90	264,771,722.41
1.1.6	Бусад мөнгөн орлого	130,802,530.00	61,846,581.76
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	677,744,861.39	564,811,384.26
1.2.1	Ажиллагчдад төлсөн	173,497,558.41	167,464,805.34
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	23,573,319.85	24,037,059.98
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	730,000.00	968,850.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	20,150,554.83	19,673,578.91
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	4,920,320.00	5,280,000.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	0.00	0.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	4,555,337.00	5,255,686.00
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	64,300.00	0.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	450,253,471.30	342,131,404.03
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,454,665.51	-1,685,089.08
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	69,318.57	0.00
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0.00	0.00
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	0.00	0.00
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	69,318.57	0.00
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00
2.1.8	Бусад	0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	69,318.57	0.00
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,523,984.08	-1,685,089.08
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	209,105.00	1,733,089.08
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,733,089.08	48,000.00

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
100	I.НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II+V)	305,403,836.00	550,703,229.26	245,299,393.26	180.32
105	II.НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН (III +IV )	305,403,836.00	550,703,229.26	245,299,393.26	180.32
110	III. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	305,403,836.00	550,703,229.26	245,299,393.26	180.32
115	Бараа ажил үйлчилгээний зардал	304,903,836.00	543,953,229.26	239,049,393.26	178.40
120	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	189,767,400.00	167,464,805.34	22,302,594.66	88.25
130	Үндсэн цалин	170,748,000.00	155,264,512.59	15,483,487.41	90.93

**“АТҮТ” ТӨҮГ-ын Булган аймаг дахь Авто тээврийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

141	Хоол, унаа	9,030,000.00	6,635,000.00	2,395,000.00	73.48
142	Нэмэгдэл цалин	9,989,400.00	5,565,292.75	4,424,107.25	55.71
145	Нийгмийн даатгалын шимтгэл	27,516,276.00	24,037,059.98	3,479,216.02	87.36
150	Төлсөн татварууд	6,133,920.00	5,255,686.00	878,234.00	85.68
170	ХХОАТ	1,500,000.00	650,000.00	850,000.00	43.33
180	Үл хөдлөхийн татвар	4,444,820.00	4,444,821.00	-1.00	100.00
185	Тээврийн хэрэгслийн татвар	189,100.00	160,865.00	28,235.00	85.07
190	Бараа, үйлчилгээний урсгал зардал	81,486,240.00	347,195,677.94	265,709,437.94	426.08
200	Гэрэл цахилгааны зардал	4,200,000.00	2,398,714.91	1,801,285.09	57.11
210	Түлш, халаалтын зардал	13,490,400.00	15,417,600.00	-1,927,200.00	114.29
220	Цэвэр, бохир усны зардал	1,200,000.00	1,857,264.00	-657,264.00	154.77
270	Бичиг хэргийн материал	1,920,000.00	883,350.00	1,036,650.00	46.01
280	Тээвэр, шатахууны зардал	6,470,000.00	4,480,000.00	1,990,000.00	69.24
290	Шуудан холбооны зардал	960,000.00	659,590.00	300,410.00	68.71
300	Дотоод томилолтын зардал	4,001,000.00	4,372,500.00	-371,500.00	109.29
301	Хяналт шалгалтын зардал	0.00	1,215,000.00	-1,215,000.00	0.00
320	Ном, хэвлэлийн зардал	128,000.00	85,500.00	42,500.00	66.80
330	Хог хаягдал устгах, цэвэрлэх	360,000.00	220,000.00	140,000.00	61.11
350	Холбооны суваг ашигласны төлбөр	1,560,000.00	0.00	1,560,000.00	0.00
361	Сэлбэг хэрэгсэл	1,500,000.00	800,000.00	700,000.00	53.33
363	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,820,000.00	5,731,620.00	-1,911,620.00	150.04
370	Ахмадын жилийн зардал	1,380,000.00	3,060,000.00	-1,680,000.00	221.74
380	Төлбөр, хураамж, жижиг татварууд	1,250,000.00	1,438,876.00	-188,876.00	115.11
390	Өвөлжилтийн бэлтгэл	1,000,000.00	1,800,000.00	-800,000.00	180.00
410	Болзошгүй тохиолдлын зардал	600,000.00	1,394,220.00	-794,220.00	232.37
413	Улсын мэдээллийн маягт хэвлэх	1,320,000.00	0.00	1,320,000.00	0.00
450	Гадаад зочин, баяр ёслолын зардал	1,000,000.00	1,050,000.00	-50,000.00	105.00
460	Бусад зардал	34,319,640.00	0.00	34,319,640.00	0.00
480	Мэдээлэл сурталчилгаа	640,000.00	300,500.00	339,500.00	46.95
490	Даатгал-Тээврийн хэрэгслийн	187,200.00	0.00	187,200.00	0.00
520	Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	500,000.00	6,750,000.00	-6,250,000.00	1,350.00
525	Санхүүжилт	0.00	239,731,343.01	239,731,343.01	0.00
526	Хянан баталгаажуулалтын зардал	0.00	60,180,000.00	-60,180,000.00	0.00
527	Банкны хураамж	180,000.00	119,600.02	60,399.98	66.44
535	Чөлөөлөгдөж буй ажилчдын тэтгэмж	0.00	14,108,155.00	-14,108,155.00	0.00
640	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	563,126,295.18	563,126,295.18	0.00
685	Ажиллагсад бүгд	14.00	0.00	14.00	0.00
690	Удирдах ажилтан	1.00	0.00	1.00	0.00
695	Гүйцэтгэх ажилтан	9.00	0.00	9.00	0.00
700	Үйлчлэх ажилтан	4.00	0.00	4.00	0.00

### **3. Санхүүгийн тайлангийн тодруулга**

#### **3.1 Байгууллагын үйл ажиллагаа**

Монгол Улсын засгийн газрын тогтоолоор Тээврийн төвийн Булган аймаг дахь салбар нь анх 2005 оны 04 сарын 01-нд үүсгэн байгуулагдсан.

Зам, тээвэр барилга хот байгуулалтын сайдын 2009 оны 56-р тоот тушаалаар “Авто тээврийн тухай хууль”-ийн 17.1-д заасан үйл ажиллагаа чиглэлийн дагуу тээврийн хэрэгслийн оношилгоо, хяналт зохицуулалтын алба байгуулагдаж, 2009 оны 10 сарын 01-нэс эхлэн Булган аймаг дахь салбар болон тус тус өргөжсөн билээ.

Засгийн газрын 2013 оны 336-р тогтоол, 2015 оны 02 сарын 09-ний өдрийн 55 дугаар тогтоолоор Авто тээврийн төв болон дараах батлагдсан бүтэц, орон тоо, зохион байгуулалтаар үйл ажиллагаа явуулсан.

“АТҮТ” ТӨҮГ-ын Булган аймаг дахь Авто тээврийн төв нь орон нутагт Авто тээврийн техникийн хяналтын үзлэг хийх, хот хооронд, орон нутгийн зорчигч тээвэр, ачаа тээврийн хөдөлгөөнийг шуурхай удирдлагаар хангах, зохион байгуулах, тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих хяналтыг сайжруулах, бүртгэлжүүлэх, шилжилт хөдөлгөөн хийх, Авто үйлчилгээ, мэргэшсэн жолооч, хот орчмын такси үйлчилгээг явуулах зэрэг үндсэн чиг үүргийн ажлуудыг хэрэгжүүлж байна.

Булган аймагт 17400 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаагаас жилд дунджаар 10000 тээврийн хэрэгсэл техникийн хяналтын үзлэгт хамрагдаж замын хөдөлгөөнд оролцох эрх авдаг. Орон нутагт нийтийн зорчигч тээврийн чиглэлээр Залман хангай, Булган жолоо ХХК, Хот хоорондын чиглэлд Эрдэмтранс, Хараацайн жигүүр ХХК-ууд тээвэрлэлт эрхлэн явуулж байна.

#### **3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин**

Булган аймаг дахь Авто тээврийн төв ТБӨӨААН 2005 байгуулсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;” гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр өөрчлөлт орсон.
- Хөдөлмөрийн тухай хууль 2022 оны 01 дүгээр сарын 1-ээс эхлэн хүчингүй шинэ хууль мөрдөгдөнө.
- Татварын хууль тогтоомж
- Нийгмийн даатгалын тухай хууль
- ТБОНӨХБАҮХАТ Хууль

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн хүснэгтийн тэтгэврийн даатгал-ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "9.5" гэснийг "8.5" гэж, тэтгэврийн даатгал-даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "9.5" гэснийг "8.5" гэж, шимтгэлийн дүн-ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "12.7" гэснийг "11.7" гэж, шимтгэлийн дүн-даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "12.5" гэснийг "11.5" гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн "12.5 хувиас" гэснийг "11.5 хувиас" гэж тус тус өөрчилсөн.
- Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолд 2021 оны 207 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулж 1 дэх заалтын “7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл” гэснийг “12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал” гэж өөрчилсөн.

### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого**

“АТҮТ ” ТӨҮГ-ын Булган аймаг дахь Авто тээврийн төв санхүүгийн Unicus программыг ашигладаг бөгөөд тус программд нэвтрэх 1 эрхтэй ажилтантай ерөнхий нягтлан бодогч, нярав нар өдөр тутмын ажил гүйлгээг оруулж байна.

Харин тус программд үндсэн хөрөнгийг дэлгэрэнгүй оруулахдаа эд хариуцагч бүрийн нэрийг хөрөнгө бүрийн ард тусгаж өгсөн нь хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах арга хэмжээ авсан байна.

### **3.4 Санхүүгийн тайлангийн тодруулга**

“АТҮТ” ТӨҮГ-ын Булган аймаг дахь Авто тээврийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 35,664.6 мянган төгрөгөөр буюу 5.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,733.00	48.00	-1,685.00
Авлага			0.00
Бараа материал	11,208.40	10,041.90	-1,166.50
Үндсэн хөрөнгө	585,317.00	570,376.60	-14,940.40
Биет бус хөрөнгө	28,090.00	28,090.00	0.00
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>626,348.60</b>	<b>608,508.50</b>	<b>-17,840.10</b>
Урьдчилж орсон орлого	2,462.10	6,597.80	4,135.70
Өр төлбөрийн дүн		17.824.5	17.824.5
Хуримтлагдсан ашиг	-308,306.90	-306,256.20	2,050.70
Төв компанийн тооцоо	923,193.40	881,342.40	-41,851.00
Эздийн өмч	9,000.00	9,000.00	0.00
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>626,348.60</b>	<b>608,508.50</b>	<b>-17,840.10</b>

Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэл 00.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Банк дахь мөнгөний үлдэгдэл 48.0 сая төгрөг болж өмнөх оноос 1,685.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Тайлангийн хугацааны эцэст авлагын үлдэгдэлгүй. Тайлангийн хугацаанд төв компанийн тооцооноос бусад 368,532.6 мянган төгрөгийн авлага үүсгэж барагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 10,041.9 мянган төгрөг болж 1,166.5 мянган төгрөгөөр буурсан нь бичиг хэргийн материалын үлдэгдэл өсөж, хангамжийн материал, аж ахуйн материал буурснаас шалтгаалжээ. Бараа материалын 10,041.9 мянган төгрөгийн үлдэгдлийн 23 хувийг бичиг хэргийн материал, 75 хувийн хангамжийн материал, үлдсэн 2 хувийг бусад болон сэлбэг хэрэгслийн материал эзэлж байна.

Тайлант онд худалдан авалтаар 20,895,4 мянган төгрөгийн бараа материал нэмэгдсэн ба үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал байхгүй байна. Тайлангийн хугацаанд 22,110.1 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө 2021 оны эхэнд 613,407.0 мянган төгрөг байсан бол тайлант хугацаанд 2,516.4 мянган төгрөгийн компьютер техник хэрэгсэл үнэ төлбөргүй орлогод авсан, АТҮТ ТӨҮГ-ын захирлын 2021 оны 11 сарын 11-ны өдрийн А/276 тоот тушаалаар элэгдлээрээ өртгөө нөхсөн тоормос шалгагч төхөөрөмжийг үнэлгээ хийж 17,329.3 мянган төгрөгөөр үнэлэн хөрөнгөд бүртгэсэн, 3,665.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 885.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил акталж оны эцсээр 598,466.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Жилийн эцсийн тооллогыг байгууллагын даргын 2021 оны 12 -р сарын 14-ны А/304 тоот тушаалаар хийж тооцоо бодож баталгаажуулсан байна.

АТҮТ ТӨҮГ-аас татаас санхүүжилтийн орлого 2021 оны төсөөлөл 271,084.9 мянган төгрөгөөр хийснээс тайлант хугацаанд дансаар нийт 264,771.7 мянган төгрөгийн санхүүжилт орж ирсэн байна. Татаас санхүүжилтийн орлогыг Булган аймаг дахь Авто тээврийн төв нь төв компанийн тооцоо дансанд бүртгэдэг байна. Тус данс нь 923,193.4 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй тайлангийн хугацаанд 273,818.3 мянган төгрөг нэмэгдэж 315,669.5 мянган төгрөг хасагдаж 881,342.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болсон байна.

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт компанийн тайлант хугацаанд гарсан өртөг, зардлыг ашиглалт, засвар, үйлчилгээ, ерөнхий удирдлага, борлуулалт маркетинг гэсэн өртгийн төвүүдэд аккруэл сууриар бодитой, үнэн зөв тооцож, тайлант хугацаанд нь зохистой ангилж, хуваарилж бүртгэх, үйл ажиллагааны бусад зардлыг аккруэл сууриар зөв, тооцож бүртгэхээр заасан байна.

### **3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Авто тээврийн төвийн ТБӨААН-ийн санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Тайлангийн хугацаанд гүйцэтгэлээр 306,190.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 304,139.6 мянган төгрөгийн зардал гарган, 2,050.0 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт үйл ажиллагааны орлогыг 274,680.0 мянган төгрөг төлөвлөснөөс 306,190.4 мянган төгрөг буюу 109.4 хувиар давсан байна.

#### **Орлогын төлөвлөгөө биелэлт**

Орлогын төрөл	2021 он	Гүйцэтгэл	Хувь
---------------	---------	-----------	------

**“АТҮТ” ТӨҮГ-ын Булган аймаг дахь Авто тээврийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Техникийн хяналтын үзлэг	245,000.0	268,091.1	109,4
Хот хоорондын тээвэр	15,600.0	6,733.7	43,1
Орон нутгийн тээвэр	4,216.3	1,192.4	28,2
Бүртгэлийн орлого	9,864.0	30,173.1	305,8
<b>Нийт</b>	<b>274,680.0</b>	<b>306,190.4</b>	<b>111,4</b>

2021 онд цар тахлын хөл хорио цээрийн улмаас тээврийн үйл ажиллагаа хязгаарлагдаж орлогын төлөвлөгөө тасарсан хэдий ч бусад үйл ажиллагаандаа анхаарч ажиллан орлогын төлөвлөгөөг 109 хувиар давуулан биелүүлсэн үзүүлэлттэй байна. Үүнд: Техникийн хяналтын үзлэгийн орлого 268,091.1 мянган төгрөг, бүртгэлийн орлого 30,173.1 мянган төгрөг байна. Бүртгэлийн

Тайлангийн хугацаанд 6,597.8 мянган төгрөгийн урьдчилж орсон орлого орлогод бүртгэгдсэн байна. Орон нутгийн тээврийн орлого Булган жолоо, Залман хангай гэсэн үндсэн 2 орон нутгийн тээврийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагаас, Хот хоорондын тээврийн орлого УБ-БУ-УБ чиглэлийн Эрдэмтранс, Хараацайн жигүүр гэсэн 2 үндсэн байгууллагаас оруулсан орлогоос бүрдэж байна.

Үйл ажиллагааны зардлын 2021 оны төсөөлөл 271,084.1 мянган төгрөгөөр хийснээс тайлант хугацаанд дансаар нийт 265,242.0 мянган төгрөгийн санхүүжилт орж 265,241.4 мянган төгрөгийн зарцуулалт гарсан байна.

<b>Зардлын нэр</b>	<b>2021 оны төсөв төсөөлөл</b>	<b>Санхүүжилт</b>	<b>Зарцуулалт</b>
Ажиллагсдад төлсөн цалин	170,748.0	155,265.1	155,264.5
Нэмэгдэл	9,989.4	5,565.2	5,565.2
Хоол унаа	9,030.0	6,635.0	6,635.0
НДШ	27,516.2	24,037.0	24,037.0
Бичиг хэрэг	1,920.0	883.3	883.3
Ном хэвлэл	128.0	85.5	85.5
Ашиглалтын зардал	4,200.0	2,398.7	2,398.7
Халаалт	13,490.4	15,417.6	15,417.6
Цэвэр бохир ус	1,200.0	1,857.2	1,857.2
Тээвэр шатахуун	6,470.0	4,480.0	4,480.0
Сэлбэг хэрэгсэл	1,500.0	800.0	800.0
Хаот		650.0	650.0
ҮХХ татвар	4,444.8	4,444.8	4,444.8
ТХ татвар	189.1	160.8	160.8
Шуудан холбоо	960.0	659.5	659.5
Албан томилот	4,001.0	4,372.5	4,372.5
Гадаад зочин баяр ёслол	1,050.0	1,050.0	1,050.0
Төлбөр хураамж	1,250.0	1,097.4	1,097,460.4
Хөдөлмөр хамгаалал	3,820.0	5,731.6	5,731.6
Газрын төлбөр		341.4	341.4
Мэдээлэл сурталчилгаа	640.0	300.5	300.5
Ахмадын жилийн зардал	1,380.0	3,060.0	3,060.0
Хог хаягдал	360.0	220.0	220.0
Болзошгүй	600.0	1,394.2	1,394.2
Нэг удаагийн буцалтгүй	500.0	6,750.0	6,750.0
Чөлөөлөгдөж буй ажилтны тэтгэмж	14,108.1	14,108.1	14,108.1
Банкны шимтгэл	180.0	84.1	84.1
Өвөлжилтийн бэлтгэл	1,000.0	1,800.0	1,800.0
Хяналт шалгалтын зардал	1,500.0	1,215.0	1,215.0
Холбооны суваг ашигласны	1,560.0		
Улсын мэдээллийн маягт хэвлэх	1,320.0		
Бусад		374.0	374.0
<b>Нийт</b>	<b>271,084.1</b>	<b>265,242.0</b>	<b>265,241.4</b>

## **4. Аудитын тайлан**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “АТҮТ” ТӨҮГ-ын Булган аймаг дахь Авто тээврийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад зардал, нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Бэйкер тилли Далайван аудит ХХК-ийн Орхон аймаг дахь салбар ахлах аудитор, захирал Д.Мягмарсүрэн, аудитор Б.Пүрэвсүрэн нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган аймгийн Авто тээврийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 21-ны 29 тоот албан бичгээр ирүүлсэн болно.

### **4.2 Дотоод хяналт**

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь тухайн үед мөрдөгдөж байсан холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн бөгөөд тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирч байсан хэдий ч 2020-2021 онд шинэчлэгдсэн хууль, журам, стандартын өөрчлөлтийг тусгаж шинэчлээгүй байна.

Монгол улсын Засгийн газрын 311-р тогтоолын дагуу Дотоод хяналт шалгалт хийх ажлын хэсгийг 2021 оны 10 сарын 27-нд шинэчлэн байгуулж Булган аймгийн Авто тээврийн төвийн техникийн хяналтын үзлэгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг хийсэн. Хяналт шалгалтаар хууль тогтоомж, стандарт журмын мөрдлөг, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, орлого болон үйл ажиллагааны төлөвлөгөө, техникийн хяналтын өдрийн гүйлгээний баримтын тулгалт хийж баталгаажуулан тайланг Төв компанийн Дотоод хяналт үнэлгээний хэлтэст хүргүүлэн ажилласан.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

“АТҮТ” ТӨҮГ-ын Булган аймаг дахь Авто тээврийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

#### **4.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 305,403,8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 3,054.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,137.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **5.1 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тухай бүр оруулах нийт -96, Сар бүрийн 36, Улирал тутмын 4, Хагас жилд оруулах -3, Бүтэн жилд оруулах -9 мэдээлэл нийт 148 мэдээллээс хугацаандаа оруулсан 147, хугацаа хоцроосон 1 мэдээлэл байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг үнэн зөв мэдээлж байх, үр нөлөөтэй хяналт хэрэгжүүлж, хариуцлага тооцох зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

#### **5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Нэг удаагийн буцалтгүй тусламж болох ахмадуудад дэмжлэг үзүүлэх тэтгэмжүүдээс ХХОАТ тооцоогүй зэрэг нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22.1.1.”хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон

нэг удаагийн буцалтгүй тусламж чөлөөлөгдөнө " гэсэн заалттай нийцээгүй байна. Мөн дахин үнэлгээний бичилт буруу хийгдсэн байна.

## **6. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн аудитын байгууллага шалгалт хийгээгүй “АТҮТ” ТӨҮГ-ын дотоод аудитаас шалгалт хийгдсэн боловч шалгалттай холбоотой материал байхгүй гэх шалтгаанаар бидэнд ирүүлээгүй болно.

## **7. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүгийн тооцоолол, бүртгэл тайлагнал, санхүүгийн тайлангийн уялдаа холбоо, тодруулга тайлангууд гардаггүй, ерөнхий журнал гүйлгээ баланс хоорондоо таарахгүй зэрэг нь цаашид анхаарах шаардлагатай. Тайлангийн хугацааны журнал бичилт гүйлгээ баланс, дэлгэрэнгүй тайлангуудад үндсэн хөрөнгийн дансдын эхний үлдэгдлийг тайлангийн хугацаанд орсон гарсан гүйлгээгээр бичилт хийдэг байна. Нягтлан бодогч шинэ учраас программын болон тайлангуудын талаар мэдлэг бага байсан. Мөн үндсэн хөрөнгө, бараа материалыг бодит үнэ цэнээр бүртгэсэн эсэх ангилал зөв эсэхийг дараагийн аудитаар нарийвчлан авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

Төв ба салбар компанийн бүртгэлийг төв компанийн тооцоо дансанд зөв бүртгэж байгаа эсэхийг шалгах.

## **8. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 582.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, шилэн данстай холбоотой тоон мэдээлэлгүй нэг алдаа нийт 3 зөвлөмж өгсөн болно. Төлбөрийн акт , албан шаардлага хүргүүлж байхгүй зөрчил нь материаллаг бус тул зөрчилгүй дүгнэлт өглөө.байна.

### **8.1 Залруулсан алдаа**

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитад залруулсан алдаа байхгүй.

### **8.2 Акт**

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар гаргасан алдаа зөрчилд акт хүргүүлээгүй болно.

### **8.3 Албан шаардлага**

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар гаргасан алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлээгүй болно.

### **8.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Зардалтай холбоотой асуудал**

##### **Илрүүлэлт:**

1. Нэг удаагийн буцалтгүй тусламж болох ахмадуудад дэмжлэг үзүүлэх 3060.0 мянган төгрөг, шинэ хүүхэдтэй болсон 300.0 мянган төгрөг, ар гэрийн гачигдалд тохиолдсон 100.0 мянган төгрөг, бэлэг дурсгалын зүйлийн 500.0 мянган төгрөг зэрэг тэтгэмжүүдээс 369.0 мянган төгрөгийн ХХОАТ тооцоогүй байгаа нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22.1.1.хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн

буцалтгүй тусламж чөлөөлөгдөнө гэсэн заалтыг зөрчиж үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Групптэй ажилтны амралтын бодохдоо групптэй хүнд нэмж олгох 5 хоногийг нэмж амруулаагүй 5 хоногийн амралтын мөнгийг ажилласан цалингаар бодож 186,0 мянган төгрөг дутуу олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 99.4-т "Хөгжлийн бэрхшээлтэй болон 18 насанд хүрээгүй ажилтны ээлжийн үндсэн амралтын хугацаа ажлын 20 өдөр байна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:**

1. Дотоод журамд заасан тэтгэмжүүд чөлөөлөлтөд хамрагдахгүй учир татварыг тооцоолон суутгаж байх .
2. Амралтын хоногийг нэмж биеэр эдлүүлэн амралтын мөнгийг бүрэн тооцож олгох.

**2. Шилэн данстай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:**

Шилэн дансанд тайлангийн хугацаанд 147 мэдээ мэдээлэхээс 146-ийг мэдээлж 1 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх; 4.1.3."тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтын дагуу хугацаанд нь мэдээлж байх гэсэн заалтыг зөрчиж эрх ба хувиарлалт гэсэн батламж мэдэгдлийг байна.

**Өгсөн зөвлөмж:**

1. Шилэн дансны мэдээллийг үнэн зөв мэдээлж байх, үр нөлөөтэй хяналт хэрэгжүүлж, хариуцлага тооцох.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**АУДИТЫН ТАЙЛАНГ**

**БЭЛТГЭСЭН:**

“БЕЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ” ХХК-ИЙН ОРХОН АЙМАГ ДАХЬ САЛБАРЫН

АУДИТОР:



Б.ПҮРЭВСҮРЭН

**ХЯНАСАН:**

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР, ЗАХИРАЛ :



Д.МЯГМАРСҮРЭН

**АНХАН ШАТАНД ХЯНАСАН:**

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР:



Ж.ЭНХЦОДОЛ

**ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:**

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

  
331744736  
ГТ 240048 3190269

Д.АНХБАЯР

## 9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	/мянган төгрөгөөр/											
					Нийт алдаа, зөрчлийн дүн		Залруулга		Акт		Үүнээс Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1			Нэг удаагийн буцалтгүй тусламж болох ахмадуудад дэмжлэг үзүүлэх 3060.0 мянган төгрөг, шинэ хүүхэдтэй болсон 300.0 мянган төгрөг, ар гэрийн гачигдалд тохиолдсон 100.0 мянган төгрөг, бэлэг дурсгалын зүйлийн 500.0 мянган төгрөгийн тэтгэмжүүдээс ХХОАТ тооцоогүй.												1	50000
2	Булган аймаг дахь Авто тээврийн төв	БУА-2022/4/НА-СТА-ТБӨӨААН	Групптэй ажилтны амралтын бодохдоо групптэй хүнд нэмж олгох 5 хоногийг нэмж амруулаагүй 5 хоногийн амралтын мөнгийг ажилласан цалингаар бодож олгосон байна. Групп тогтоолгосон ажиллагсдын цалингаас 2 492.1 мянган төгрөгийн ХХОАТ-ийг суутган тооцсон байна.												1	
3			Шилэн дансанд тайлангийн хугацаанд 147 мэдээ мэдээлэхээс 146-ийг мэдээлж 1 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.												1	
4			Тайлангийн хугацааны эцэст нийт 535.9 мянган төгрөгийн гүйлгээ е баримтгүй анхан шатны баримтын бүрдэлгүй хийгдсэн байна. Мөн 25.0 мянган төгрөгийн гүйлгээнд хувь хүний сугалаатай баримт хавсаргасан байна.												1	
<b>ДҮН</b>																